



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

№70 /514/ 2023.05.01

Цаг үе, үйл явдал

МОРЬТОН ДАЙЧИД ЭРДЭНЭТ ХҮНИЙ АМЬ АВАРЛАА



Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн байлдагч Г.Өнөболдыг харуулын цэгт үүрэг гүйцэтгэж байх үед тус ангийн байрлалын ойролцоо 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс 29-нд шилжих шөнийн 01.00 цагийн үед авто машин осолдсон байна.

Харуулчин байлдагч ангийн жижүүртээ уг мэдээг шуурхай хүргэн, ангийн жижүүр, харуулын дарга нар ослын газар очиход 2 иргэн машин дотроо ухаангүй байдалтай байсан ба тэдэнд эмнэлгийн анхан шатны тусламжийг яаралтай үзүүлж, түргэн тусламж дуудаж

хүлээлгэн өгч амь насыг нь аварсан байна. Дээрх хоёр иргэн одоогоор Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлж, биеийн байдал нь сайжирч байгаа ба албан үүргээ гүйцэтгэж байх үедээ эрдэнэт хүний аминг цаг алдалгүй аварсан дэслэгч Н.Бумбаяр, ахлах ахлагч Б.Ганбаяр, байлдагч Г.Өнөболд нарт нутгийн удирдлага, цагдаа, эмнэлгийн байгууллага, ар гэрийн төлөөлөл талархал илэрхийлээд байна.

Ахлах дэслэгч Б.МӨНХБАЯР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌧️ -2


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	🌧️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,467	3,472
EUR 🇪🇺	3,837	3,850
CNY 🇨🇳	502	503.50
RUB 🇷🇺	42.20	42.60
JPY 🇯🇵	25.60	26.10
KRW 🇰🇷	2.59	2.61

ЗУРХАЙ



2023.05.01 /ДАВААГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 7

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:
Эрхтэн хурц болно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.35-20.04
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

УИХ-ЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ГЕНЕРАЛУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



орнуудын хувьд парламентат тогтолцоог нь онилж, мэдээлэл, сэтгэл зүй, цэрэг-улс төрийн нөлөөллийн арга технологийг ашиглан тогтворгүй байдал үүсгэхэд чиглэх болсныг та бүгд анзаарч буй биз ээ. Манай улсын хувьд их гүрнүүдийн геополитик, геостратегийн сөргөлдөөний талбар болох эрсдэл өнөөгийн цаг үед тулгарч байна. Тиймээс аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ

цолыг бий болгож, олгож эхэлснээс хойших 79 жилийн хугацаанд 216 цэргийн зүтгэлтэн энэ эрхэм цолыг хүртжээ. Тэдгээр эрхмүүдийг төлөөлөн генерал С.Баасанхүү үг хэлсэн. Тэрбээр, Монгол Улсын генералууд улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангах, хил хязгаарын халдашгүй байдал,



Жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг “Монгол генералын өдөр” болгон тэмдэглэж, алтан мөрдөстэй генералууддаа хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. Тус уламжлалын дагуу Монгол Улсад генерал цол олгож эхэлсний түүхт 79 жилийн ойн энэ өдөр Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар генералуудыг Төрийн есөн хөлт цагаан тугнаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ.

1944 оны 04 дүгээр сарын 28-нд БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 52 дугаар тогтоолоор төр, цэргийн зүтгэлтэн 11 хүнд генерал хэмээх дээд цолыг анх удаа олгосон түүхтэй юм байна. УИХ-ын дарга Г.Занданшатар, эх орноо батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, төрт ёсыг сахиулах, иргэдийнхээ амар амгалан амьдралын баталгааг хангах ээлжгүй манааны тэргүүн шугамд зогсож, Монгол Улсын Зэвсэгт хүчин, тусгай чиг үүрэгтэй албадын үйл ажиллагааны бахархал, нэр хүндийн илэрхийлэл болсон Та бүхэнд Монгол генералын өдрийн чин сэтгэлийн мэндчилгээг Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа өргөн дэвшүүлье гэлээ.

агуулга нь эх орныхоо тусгаар тогтнол, халдашгүй бүрэн эрх, аюулгүй байдлын төлөө тангараг өргөж, хошуучлан зүтгэсэн эх орны эрэлхэг хөвгүүдээрээ бахархах, хүндлэн дээдлэх, тэдний дайчин уламжлалыг үр хойчдоо өвлүүлэх, Монгол генералын бахархлыг өргөн мандуулахад чиглэдэг гэдгийг УИХ-ын дарга онцлоод, алтан мөрдөстэн Монгол генералуудын сүр жавхлан, золбоо хийморь, мэдлэг ухаанаар Монголын ард түмэн үеийн үед бахархсаар ирсэн эрхэм хүндлэл мөнх оршино гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.

Тэрбээр, XXI зуунд хүн төрөлхтөн мэдлэг, мэдээллийг эрхэмлэж, шинжлэх ухаан, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, өндөр технологи нь бидний салшгүй хэрэглээ болжээ. Түүний ачаар дайн, халдварт өвчин, байгалийн гамшгийн үзэгдлүүдийг дэлхий нийтээрээ хянаж сурлаа. Гэвч их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй сөргөлдөөн, шинэ хүйтэн дайны аюул, гаднын зөөлөн хүчний бодлого, цэрэг, дипломатын харилцааны ярвигтай асуудлууд бидэнд олон талт сорилтыг бий болгож байгаа билээ.

Шинэ төрлийн хосолмол дайны зорилго нь ардчилсан улс

хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоо бүрдүүлэхэд эрхэм генерал та бүгдийн мэдлэг, туршлага, бодлого, зөвлөмж нэн чухлаар тавигдаж байгааг онцлон тэмдэглэв. Хүндэт генералууд аа, Монголчуудын цэргээ засах эрдэм ухаан дэлхийд зартай. Эзэн Богд Чингисийн суут жанжин Мухулай, Сүбээдэйгээс эхлээд жанжин Сүхбаатар, Хатанбаатар Магсаржав, залуу жанжин Ж.Лхагвасүрэн, “парад” Ёндон гэх мэт эх орончид, генералуудын гавьяат үйлс, домогт амьдрал Монголын бахархал юм.

Цэргийн дарга, жанжууд нь эгэл түмнээсээ тодордог, дайчин цэргүүдээ эцгийн ёсоор хайрлан халамжилдаг нь монгол цэргийн ямагт ялан дийлэх арга ухааны нэгэн “нууц” нь болсоор иржээ.

Монгол Улсын шинэ үеийн цэргийн дарга, генералууд ялгуусан энэ уламжлалаа ямагт нэр төртэй сахин хадгалж, дэлхийн халуун цэгт ч энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж, монгол цэргийн хийморь жавхааг ертөнцөд дуурсгасаар байгаад талархал илэрхийлье.

Эх орон, ард түмнээ батлан хамгаалагчдын дэрвэх туг, дээдлэх сүлд нь болсон эрхэм генералууд Та бүхэндээ идрийн золбоо, эр цэргийн хийморь, урт нас, удаан жаргалыг хүсэн ерөөе гэлээ.


Монгол Улсын төр засгаас генерал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБАНААС ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАВ



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тээврийн бүлгийн автомашинуудын техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах зорилгоор Зэвсэгт хүчний 124, 189 дүгээр ангиудад ажиллаж хяналт шалгалт явууллаа.

Шалгалтаар ангиудын тээврийн бүлгийн автомашинуудын техникийн бүрэн бүтэн байдал, жолооч нарын бичиг баримт, тавиулан, авто техник хариуцсан офицер, ахлагч, ажилтан, алба хаагчдын үйл ажиллагаанд шалган туслах ажлыг зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар автотехник хариуцсан офицеруудад заавар, зөвлөмж өгч ажилласан юм.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,108,868

Эдгэрсэн

Нийт: 659,663,264

Нас барсан

Нийт: 6,863,787

Цахим шууданд

“АЛСЫН ХАРАА-2050 ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ” ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ ХИЙЛЭЭ



Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний шат болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг таниулах сургалтыг явууллаа.

Сургалтыг Монгол Улсын Засгийн газрын харьяа Удирдлагын академи, Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын албанаас зохион байгуулж байгаа “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг тайлбарлах сургагч багш бэлтгэх дамжаанд хамрагдсан захирагчийн орлогч, Ерөнхий инженер дэд хурандаа А.Ууганбаяр, сургалтын албаны дарга хошууч П.Отгонбаатар нар удирдан явуулсан юм.

Сургагч багш нар хугацаат цэргийн алба хаагчдыг таван бүлэгт хуваарилан урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүн, боловсруулалтын талаар ойлголт өгч, дасгал ажил гүйцэтгүүлсний зэрэгцээ Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд “Залуу хүн миний оролцоо” сэдвээр эсээ бичүүллээ.

Ахмад Ц.ЭРДМИЙНТУЯА

“ГЭР БҮЛ БОЛ НИЙГМИЙН ИРЭЭДҮЙ” ӨДӨРЛӨГӨӨР...



БЗД-ийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга цагдаагийн хошууч Г.Баяр-Эрдэнэ “Цахим гэмт хэрэг, мөрийтэй тоглоом”, Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч А.Дэлгэрцэцэг “Гэр бүлийн хүчирхийлэлд хэн хохирогч болдог вэ?”, Цахим мэдээлэл хариуцсан мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Б.Уянга “Цахим орчин ба нөлөөлөл”, Гэр бүлийн сургууль ТББ-ын захирал Г.Бат-Оргил “Гэр бүлийн боловсрол”, Эрчүүд гэр бүл, хүүхэд хөгжлийн нийгэмлэгийн тэргүүн Д.Эрдэнэцогт “Нийгэм дэх эрчүүдийн байр суурь ба жендерийн харилцаа” сэдвээр тус тус мэдээлэл хийж бие бүрэлдэхүүний сонирхсон асуултад хариулах замаар хууль эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлсэн юм.

Үргэлжлүүлэн нийт бие бүрэлдэхүүн ёс зүй бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгтээ хамрагдлаа. Үзлэгийг удирдамжийн дагуу цэргийн нийтлэг дүрмүүд, сэтгэл зүйн бэлтгэл, Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хүрээнд боловсруулсан сорил судалгаагаар, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартын дагуу явуулж дүгнэсэн юм.

Хошууч н.ДЭРДЭНЭНИНЖ

Зэвсэгт хүчний 084 дүгээр анги

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч-ийн нэрэмжит ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтох үзлэгийн хүрээнд “Гэр бүл бол нийгмийн ирээдүй” сэдэвт өдөрлөгийг ТББ, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Өдөрлөгөөр СЭМҮТ-ийн ахлах мэргэжилтэн О.Батчимэг “Стресс менежмент” түүнээс гарах арга зам,

ЦУГЛАРАЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга нарын мэдээлэл, онол арга зүйн цугларалт амжилттай явагдаж өндөрлөлөө. Мэдээлэл, онол, дадлага хэлбэрээр зохион байгуулагдсан цугларалтын төгсгөлд Хуурай замын цэргийн удирдлагууд үүрэг чиглэл өгөв.

Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал дөрвөн асуудалд голчлон ярьсан нь харилцаа хандлага, хамт олонч байдал, хүн хоорондын харилцаа, залуусаа дэмжих, хөгжүүлэх бодлого, манлайллын тухай байв. “Өнөөдөр нийгэм цаг үе эерэг харилцаа хандлагатай удирдах албан тушаалтныг шаардаж байна. Зэвсэгт хүчинд ч ялгаагүй. Удирдагч гэж ямар хүн бэ. Энэ бол харилцааны зөв арга барилтай, манлайлагч хүн. Бүхнийг хүчээр шийдээд яваад байвал хамт олны уур амьсгал, ажлын эрч хүч, үүрэг биелүүлэх байдал зэрэгт сөрөг нөлөөтэй. Та нар залуустаа итгэ. Залуучууд гэдэг насныхаа эрчээр итгэж чадвал, урамшуулж чадвал, дэмжиж чадвал юуг ч хийнэ. Байгалийн хуулиараа тэдэнд тэр эрч хүч, урам зориг, оргилсон хүсэл тэмүүлэл нь бий. Гагцхүү дэмжихэд анхаар. Даргын шийдвэр л цор ганц үнэн байдаггүйг манай залуу дарга нар ойлгох хэрэгтэй. Алба хаагчдаа сонсож, хамтын шийдвэр гаргахад анхаарч бай. Хамгийн гол нь өдөр тутмын ажил бол барагдахгүй учраас шинэ санаачилга, бүтээлч ажлыг барьж аваад хэрэгжүүлж байх хэрэгтэй. Урсгалаараа яваад

байвал дараа жил яг энэ байрандаа байна. Тэгэхээр алба хаагчдынхаа шинэ санаачилга ялангуяа инновац шингэсэн бүтээлийг нь боломжит байдлаар дэмжээрэй. Бидэнд нэг түгээмэл алдаа байдаг. Тэр нь эрсдэлээс айдаг. Хэвшвэл загвараас гарахаараа эрсдэл үүснэ гэж татгалзана. Үүнд анхаарна биз. Эцэст нь хэлэхэд бүх зүйл хоёр талтайг бодож байх хэрэгтэй” гэсэн юм.

Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр бэлэн байдал, бэлтгэлжилт, цэргийн сургалт бэлтгэл, цэргийн алба зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, ар тал хангалт, ёс зүй, сахилга бат, хугацаат цэргийн алба хаагчдад чиглэсэн арга хэмжээ, соёл хүмүүжил зэрэг олон асуудлаар үүрэг өгч, алба хаагчдаа бие дааж ажиллах чадвар, аливаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга барилд сургахыг даалгалаа. Мөн хөдөө орон нутаг болоод хот дотроо, харьяа Сургалтын төвүүд рүү хөдөлгөөн үйлдэхдээ зөвхөн баталгаатай замаар тээвэр хийж байх ёстойг хатуу анхааруулсан юм. Үүний дараа Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга нарт батламж гардуулж, албандаа урам зориг дүүрэн байж, цугларалтаас олж авсан мэдлэг мэдээллээ хэрэгжүүлэхийг захилаа.

КОМАНДЛАЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ БҮРЭН ХАМРАГДАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит ёс зүй, бие бялдрын түвшин тогтоох үзлэгийг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал амжилттай зохион байгууллаа.

Түвшин тогтоох үзлэгийн удирдамжид заагдсаны дагуу алба хаагчдаас “Цэргийн нийтлэг дүрэм”-ээр шалгалт авч, ёс зүй болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийг нийгэм-сэтгэл зүйн чиглэлээр боловсруулсан дөрвөн төрлийн асуумж, хамт олных нь үнэлгээ хэлбэрээр зохион байгуулав.

Үргэлжлүүлэн офицер, ахлагчийн дүрэмч, жагсаалч байдлыг нь жагсаалын үзлэг явуулах замаар шалгав. Ингэхдээ хүн нэг бүрийн жагсаалч, дүрэмч байдал, дүрэмт хувцасны хэрэглээнд үнэлгээ хийж, хүргэсэн бол хамгийн төгсгөлд нь буюу 4 дүгээр сарын 28-ны өдөр бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин, биеийн зохистой харьцааг нь дүгнэлээ. Бие бялдрын бэлтгэлжилтийг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Засвар

хангалтын төвийн Хужирбулан дахь Сургалтын төвийг түшиглэн явуулсан бөгөөд “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу хурд, хүч, тэсвэр, тусгай бэлтгэл, уян хатан гэсэн үзүүлэлтээр шалгав.

Үзлэг, шалгалтаас өмнө бие бялдрын бэлтгэлжилтээр нэг сарын хугацаатай сургалт болон сурган зааварлах хичээлийг командлалын Сургалт бэлтгэлтийн хэлтсийн биеийн тамирын офицер, дэд хурандаа С.Энхтайван удирдан явуулсан нь алба хаагчдад өгөгдсөн даалгаврыг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд дэмжлэг болж чадсан юм.

Энэхүү үзлэг, шалгалтын гол зорилго нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ёс зүй, бие бялдрын түвшнийг дээшлүүлэх, дүрэмч жагсаалч байдал, дүрэмт хувцасны зөв хэрэглээг хэвшүүлэх, цаашлаад төрийн тусгай алба хаагчдад чиглэсэн сургалт, бэлтгэлийг сайжруулах арга замыг оновчтой тодорхойлоход чиглэж байгаа юм.

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГЭЭР...



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит түвшин тогтоох үзлэгийн нэгдүгээр шатны үзлэгийг зохион байгууллаа.

“Дүрэмч, жагсаалч байдал”-ыг

жагсаалын үзлэг, алба, төв, хүн нэг бүрийн дүрэмч жагсаалч байдал, дүрэмт хувцасны үзлэгээр “Онолын мэдлэг”-ийг “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хүрээнд боловсруулсан тестээр, ёс зүйн байдлыг “Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хүрээнд боловсруулсан тестээр, “Сэтгэл зүйн байдал”-ыг дөрвөн төрлийн сорил, судалгаагаар, “Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин”-г “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу тогтоосон нормативаар тус тус явуулж дүнг гаргалаа.

Дэслэгч Б.БАТ-ЭНХ

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООГ ЦЭНГҮҮЛЭВ



Их эзэн Чингис хааны Аураг хотын туурь буюу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт “Монголын нууц товчоо”-г цэнгүүлэх ёслолын ажиллагааг тус сумын ЗДТГ-аас иргэд, хүүхэд, залуучуудад үндэсний өв уламжлал, түүх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулжээ.

180 метр урт монгол бичгээр ширлэж оёсон энэхүү гайхамшигт бүтээлийг цэнгүүлэхэд Хэнтий аймгийн 18 сумын 1000 гаруй хүүхэд, залуучууд, багш оролцсоны дээр иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн морьтон дайчид голлох үүрэгтэй оролцож, дэмжлэг үзүүллээ.

Ахлах дэслэгч Б.МӨНХБАЯР

